

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

|  |    |
|--|----|
| 1. Аудитын гэрчилгээ .....   | 2  |
| 2. Аудитын тайлан .....  | 4  |
| 2.1 Оршил.....   | 4  |
| 2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....  | 4  |
| 2.3 Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....   | 4  |
| 2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....  | 5  |
| 2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ ..... | 5  |
| 2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....  | 6  |
| 2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....  | 6  |
| 2.8 Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....   | 6  |
| 2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....  | 7  |
| 2.10 Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....   | 8  |
| 2.11 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....  | 9  |
| 2.12 Шилэн дансны мэдээлэл .....   | 10 |
| 2.13 Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....   | 10 |
| 2.14 Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....  | 10 |
| 3. Менежментийн захидал.....   | 11 |
| 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....   | 12 |
| 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....   | 12 |
| 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....  | 14 |
| 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....  | 16 |
| 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....   | 18 |
| 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....   | 19 |
| 4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....   | 21 |
| 5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....   | 22 |

### Товчилсон үгийн жагсаалт

|          |   |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС   | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт               |
| АОУС     | Аудитын Олон Улсын Стандарт                                 |
| АМГТГ    | Ашигт малтмал газрын тосны газар                            |
| УУХҮЯ    | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам                             |



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ  
ГАЗРЫН ДАРГА Х.ХЭРЛЭН ТАНАА

2020.02.21 № 06/586  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ашигт малтмал, газрын тосны газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Ашигт малтмал, газрын тосны газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Ашигт малтмал, газрын тосны газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2. Аудитын тайлан**

---

### **2.1 Оршил**

Ашигт малтмал, газрын тосны газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Х.Хэрлэн Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн хөрөнгө эзэмших гэрчилгээг байгууллагын нэр дээр шилжүүлэн бүртгэх зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу АМГТГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

АМГТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 25-наас 2020 оны 02 дугаар сарын 18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын аудитор И.Эрдэнэцэцэг гүйцэтгэв.

АМГТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 1/430 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3 Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

## **2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Ашигт малтмал, газрын тосны газар нь “Төрөөс геологи, уул уурхай, газрын тосны салбарын хөгжлийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх, хөрөнгө оруулагчид, хэрэглэгчдэд хөнгөн шуурхай, шударга үйлчилгээ үзүүлэх, тус салбарт явуулж буй төрийн бодлогыг хэрэгжүүлэх замаар үндэсний эдийн засгийн хөгжилд ашигт малтмал, газрын тосны салбарын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх” зорилго дэвшүүлэн ажиллажээ.

Дээрх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Үүнд:

1. Нутаг дэвсгэрийн геологи, геофизик, геохими, гидрогеологи, региональ судалгаа, ашигт малтмал, газрын тос, уламжлалт бус газрын тосны, эрэл, хайгуулын ажил, металлогенийн судалгааг аж ахуйн нэгж, байгууллагуудтай гэрээ байгуулан гүйцэтгүүлж, улс орны эрдэс баялгийн нөөцийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах, хөрөнгө оруулагчдын сонирхлыг татахуйц бүс, зангилгааг ялган, тэдгээрт төрийн захиргааны төв байгууллагын санал авч, судалгаа хийхийг санал болгох, геологийн судалгааны бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх;
2. Газрын тосны ордуудыг ашиглалтад шилжүүлэх, олборлолтыг нэмэгдүүлэх бодлогын удирдамж, гэрээний хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах;
3. Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой байдлыг хангах, хэрэглэгчдэд хөнгөн шуурхай, шударга үйлчилгээ үзүүлэх, тус салбарт явуулж буй төрийн бодлогыг хэрэгжүүлэх замаар үндэсний эдийн засгийн хөгжилд газрын тосны салбарын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх;
4. Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарт хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлэх, уул уурхайн бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээг судалж, хэтийн төлөвийг тодорхойлох, ашигт малтмал, газрын тосыг эдийн засгийн өндөр үр ашигтай, байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай техник, технологи ашиглан олборлох, баяжуулах, гүн боловсруулах, борлуулахтай холбогдсон судалгаа хийж дүгнэлт гаргах, санал зөвлөмж боловсруулах, тэдгээрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, ашигт малтмал олборлох, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын хөгжлийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх;
5. Ашигт малтмалын тухай хууль, Цөмийн энергийн тухай хууль, Газрын тосны тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор ердийн болон цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл, газрын тосны эрэл, хайгуулын болон гэрээт талбайд холбогдох үйлчилгээ үзүүлэх;
6. Эрдэс баялгийн салбарын мэдээллийн төрөлжсөн, нэгдсэн сан бүрдүүлэх, баяжуулах, боловсруулах, хэрэглэгчийг мэдээллээр хангах, мэдээллийн сангийн чиглэлээр гадаад орнууд, олон улсын байгууллагатай хамтын ажиллагааг хөгжүүлэх зэрэг салбарын хууль, үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт заасан тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

## **2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

АМГТГ-ын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой зарим талаар нийцэж байгаа ч байгууллагын үйл ажиллагааны онцлогийг бүрэн тусгаагүй байна.

АМГТГ нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Ординат компани Юникус программ хангамж ашигладаг байна.

АМГТГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

## 2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар АМГТГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 16 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг суурь болгон сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийг өөрчлөх шаардлагагүй гэж үзэн 2019 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 307,486,238.0 мянган төгрөгөөс тооцон 6,149,724.8 мянган төгрөгөөр материаллаг байдлын түвшинг тодорхойлж, баталгаажууллаа.

## 2.8 Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

АМГТГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 34,887,057.8 мянган төгрөгөөр буюу 78.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт  | Эхний үлдэгдэл      | Эцсийн үлдэгдэл     | /мянган төгрөг/     |
|---|---------------------|---------------------|---------------------|
|   |                     |                     | Өөрчлөлт            |
| Б   | 1                   | 2                   | 3=2-1               |
| Мөнгөн хөрөнгө                                    | 1,641,345.3         | -                   | -1,641,345.3        |
| Авлага  | 9,084,638.0         | 9,084,000.3         | -637.7              |
| Урьдчилгаа  | 281,936.6           | 63,503.5            | -218,433.1          |
| Бараа материал                                    | 565,049.5           | 563,814.6           | -1,234.9            |
| Нөөцийн бараа                                     | 23,175,390.4        | 23,175,390.4        | -                   |
| Үндсэн хөрөнгө                                    | 9,684,711.9         | 46,433,420.7        | 36,748,708.8        |
| <b>Нийт хөрөнгө</b>                               | <b>44,433,071.7</b> | <b>79,320,129.5</b> | <b>34,887,057.8</b> |
| Өр төлбөр   | 2,369,498.4         | 698,480.0           | -1,671,018.4        |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/               | 10,187,812.5        | 10,187,812.5        | -                   |
| <b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b> | <b>44,433,071.7</b> | <b>79,320,129.5</b> | <b>34,887,057.8</b> |

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, урьдчилгаа, үндсэн хөрөнгө, өр төлбөр дансдад материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 526,896.0 мянган, Төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг дэмжих сангийн хөрөнгөөр 484,481.8 мянган, Тогтвортой бичил уурхай төслийн хөрөнгөөр 155,100.0 мянган, урсгал зардлаас 22,581.2 мянга нийт, 1,189,059.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан, УУХҮЯ-наас 37,132,688.4 мянган төгрөгийн биет бус хөрөнгийн шилжүүлэн авсан дүнгээр

тус тус нэмэгдсэнээс шалтгаалжээ. Тайлант онд 764,346.5 мянган төгрөгийг акталж данс бүртгэлээс хассан байна.

Өр төлбөрийн дансны үлдэгдэл буурсан нь харилцах дансны үлдэгдэл 2015 онд үүссэн 500,000.0 мянган/аж ахуйн нэгжид буцаан олгох/, 2017 онд үүссэн 1,000,000.0 мянган төгрөгийн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийн дугаарыг цахим хэлбэрээр олгох үйлчилгээний хураамжийг улсын төсөвт төвлөрүүлсэнтэй холбоотой.

ААН-дэд буцаан өгөх ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийн дугаарыг цахим хэлбэрээр олгох үйлчилгээний хураамж 607,500.0 мянга, 2018-2019 онуудад үүссэн барьцаа хөрөнгийн үлдэгдэл 88,712.0 мянга, цалингийн зөрүү болон тэтгэвэрт гарч байгаа ахмадын тэтгэмжийн мөнгө 39,038.5 мянга нийт 698,480.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

## 2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар АМГТГ нь тайлант онд 404,050,000.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэх төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 298,469,772.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 26.1 хувиар тасалсан.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

| /мянган төгрөг/ |  |                       |               |                |       |
|-----------------|--|-----------------------|---------------|----------------|-------|
| №               | Орлогын төрөл  | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл     | Зөрүү          | Хувь  |
| 1               | Газрын тосны орлого  | 335,600,000.0         | 232,267,132.4 | -103,332,867.6 | -30.8 |
| 2               | Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр | 42,900,000.0          | 36,910,660.8  | -5,989,339.2   | -13.9 |
| 3               | Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр            | 2,300,000.0           | 5,532,164.3   | 3,232,164.3    | 140.5 |
| 4               | Бусад орлого   | 12,000,000.0          | 4,275,686.4   | -7,724,313.6   | -64.4 |
| 5               | Өөрийн орлого (Сонгон шалгаруулалт)                                  | 11,250,000.0          | 19,484,128.5  | 8,234,128.5    | 73.2  |
|                 | Нийт дүн   | 404,050,000.0         | 298,469,772.4 | -105,580,227.6 | -26.1 |

1. Газрын тосны борлуулалтын орлого 103,332,867.6 мянган төгрөгөөр тасарсан нь Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд газрын тосны борлуулалтын биет хэмжээг 8.15 сая баррелиар тооцож баталсан нь газрын тосны борлуулалтын орлогоос улсын төсөвт төвлөрүүлэх дүнг өндрөөр тооцож баталснаас төлөвлөгөө биелүүлэх боломжгүй болсон байна.

2. Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр 5,989,339.2 мянган төгрөгөөр тасарсан нь 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар хүчин төгөлдөр нийт 10.7 сая га талбайг хамарсан 3369 тусгай зөвшөөрөл бүртгэлтэй байсан бол 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар хүчин төгөлдөр нийт 8.7 сая га талбайг хамарсан 3078 тусгай зөвшөөрөл болж буурсан, 2019 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын 162 тусгай зөвшөөрөл цуцлагдсан, 189 хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан зэргээс шалтгаалжээ.

3. Бусад орлого 7,724,313.6 мянган төгрөгөөр тасарсан нь газрын тосны хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл, талбайн хэмжээг багассанаар кадастрын үйлчилгээ, геологийн үйлчилгээ, эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн үйлчилгээ, геологийн архивын үйлчилгээ, нүүрсний лабораторийн шинжилгээ, газрын тосны хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр болон бусад үйлчилгээний орлогууд буурснаас шалтгаалсан байна.



Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 6,479,793.2 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 3,851,543.2 мянган төгрөгийн урсгал зардал, 2,628,250.0 мянган төгрөгийн сургалтын зардал батлагджээ. Гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,851,543.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагаанаас 2,324,406.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж 6,162,612.1 мянган төгрөгийг зарцуулж санхүүжилтээс 12,833.9 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 504.0 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу санхүүждэг сургалтын урамшууллын орлого 303,843.2 мянган төгрөгөөр орлого тасарсан тул тэр хэмжээгээр зардлын гүйцэтгэл гараагүй. Төсвөөс нийт 13,337.9 мянган төгрөгийн хэмнэлттэй ажиллаж буцаан төвлөрүүлсэн.

**Нэмэлт төсөв:** 2019 онд Швейцарын хөгжлийн агентлагийн тогтвортой бичил уурхай төсөл болон Солонгосын Кигам төсөл хэрэгжиж нийт 433,228.4 мянган төгрөгийн санхүүжилт авч 395,696.0 мянган төгрөгийг зарцуулж, тогтвортой бичил уурхай төсөл 11 сард хаагдаж үлдэгдэл 4,235.9 мянган төгрөг буцаан шилжүүлж, Кигам төслөөс 33,296.5 мянган төгрөг зарцуулаагүй үлдэж Сангийн яаманд төвлөрүүлж санхүүгийн тайланд Сангийн яамнаас авах авлагаар тусгажээ.

## 2.10 Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 16 эрсдэл тодорхойлж нийт 16 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 6,214,191.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 624,168.4 мянган төгрөгийн алдааг залруулж, 570.2 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 5,560,369.7 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлж, 29,083.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Үүнд:

1. Шатахууны зардлыг нормоос 570.2 мянган төгрөгийг илүү зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1."төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах," 16.5.2."батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих," Монгол Улсын Сангийн Сайдын 2015 оны 184 дүгээр тогтоолын 2-т "албан ажлын хэрэгцээний автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтан суудлын автомашиныг хотын дотор ажлын хоногт дунджаар 50 км..... хэтрүүлэхгүй хэрэглэж байхаар тогтоосугай." заалтыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

2. Газрын тосны тухай хуулиар зөвшөөрөгдсөн, Бүтээгдэхүүн хуваах гэрээний үндсэн дээр бүрдүүлдэг "Төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг дэмжих орлого"-ыг төсөвт тусгаж батлуулалгүйгээр 1,117,831.6 мянган төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн "6.3.4.төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байх.", заалтыг хэрэгжүүлээгүй, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгах албан шаардлага өгсөн.

3. Төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 303,843.2 мянган төгрөгөөр тасалсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-т "Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ:", 41.2.1."хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заасныг тус тус зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгах албан шаардлага өгсөн.

4. Бүтээгдэхүүн хуваах гэрээний 13.4.1, 13.5.1-д заасан сургалтын урамшуулал болон төлөөлөгчийн үйл ажиллагааг дэмжих хөрөнгийн орлогыг гэрээний дагуу бүрэн төвлөрүүлээгүй, зөвхөн 2019 оны байдлаар тооцоолол хийж үзэхэд 3,844,968.2 мянган төгрөгийг төвлөрүүлэх боломжтой байна.

Шийдвэрлэсэн нь: Орлого бүрэн төвлөрүүлэх албан шаардлага өгсөн.

5. Төрийн үйлчилгээний албан хаагчдад мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт, журам батлагдаагүй, мэргэжлийн зэргийн шаардлага хангаагүй баримтыг үндэслэн 24,221.2 мянган төгрөгийн нэмэгдэл олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4. "үнэн зөв байх;" Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" заалтуудыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгах албан шаардлага өгсөн.

6. Бүртгэлээс гадуур "Эрлийн гэрээ"-гээр 10 автомашин ашиглаж байгаагаас 263,254.8 мянган төгрөгийн 3 автомашины гэрчилгээг АМГТГ-ын нэр дээр шилжүүлсэн боловч санхүүгийн тайланд бүртгээгүй. Өөрийн эзэмшилд байхгүй автомашинуудад 6,250.7 мянган төгрөгийн зардал гаргасан. Эдгээр зөрчил нь эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна. Эрлийн гэрээний 3.4.10 "Компани энэхүү гэрээний 3.1.3-т заасан АМГТГ-аас томилогдсон мэргэжилтний ажил үүргээ гүйцэтгэхэд шаардагдах 1 ш автомашин/ жийп ангиллын туулах чадвар сайн, шинэ, дизель хөдөлгүүртэй/-ыг худалдан авч АМГТГ-т буцалтгүйгээр өгнө." гэж заажээ.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгах албан шаардлага өгсөн.

Аудитаар илэрсэн 29,083.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

## **2.11 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлэх, төсөвт орлого бүрэн төвлөрүүлэх үйл ажиллагааг үр нөлөөтэй зохион байгуулж ажиллах шаардлагатай байна. Үүнд:

1. 2019 оны Улсын төсөвт төврөлүүлэх орлогыг 105,580,227.5 мянган төгрөгөөр тасалсан асуудалд анхаарал хандуулж орлогын төлөвлөгөөг биелүүлэх тал дээр үр нөлөөтэй ажил зохион байгуулах;

2. 2014-2015 онуудад улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу бүртгэл хөтлөн 12 байгууллагаас авах 8,334,146.8 мянган төгрөгийн авлага үүссэн, өмнөх оны аудитаар барагдуулах албан шаардлага өгсний дагуу тус байгууллага тодорхой арга хэмжээ зохион байгуулсан боловч авлагын дүн буураагүй, цаашид авлагыг барагдуулах талаар анхаарч ажиллах;

Аудитын цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан горим сорил хэрэгжүүлж амжаагүй дараах асуудлуудыг завсрын аудитаар нарийвчлан авч үзнэ. Үүнд:

1. Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу төсөвт орлого төвлөрүүлдэг "Сургалтын урамшуулал"-ын хөрөнгийн зарцуулалт, гэрээний хэрэгжилт;

2. Үндсэн хөрөнгөд биет тест хэрэгжүүлэх;

## **2.12 Шилэн дансны мэдээлэл**

АМГТГ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллээс Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 33 мэдээллийг хугацаанд нь, 23 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан.

## **2.13 Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 9,115,924.1 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага хүргүүлснээс олон жил дамнасан авлага, өглөгийг барагдуулах арга хэмжээ авч ажиллах, төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогын бодитой төлөвлөж, батлагдсан орлогын төлөвлөгөөг бүрэн төвлөрүүлж байх гэсэн албан шаардлагын заалт хэрэгжээгүй байна.

Нийт 6 зөвлөмж өгснөөс 4 зөвлөмжийг хэрэгжүүлж, 1 зөвлөмж хэрэгжих шатанд, газрын тосны тухай хуулиар зөвшөөрөгдсөн, бүтээгдэхүүн хуваах гэрээнд тусгагдсан "Төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг дэмжих орлого"-ыг төсөвт тусгаж батлуулах гэсэн 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

## **2.14 Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид АМГТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

АМГТГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### **3. Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1 Зардлын данстай холбоотой асуудал**

##### **3.1.1 Илрүүлэлт:**

Санхүүгийн тайланд бүртгэлтэй 29,083.0 мянган төгрөгийн үнэ бүхий соната маркийн машин "Жэй энд пи жи" ХХК-ийн нэр дээр өмчлөлийн гэрчилгээтэй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай 71 дүгээр зүйлийн 1-д "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч, ерөнхий нягтлан бодогч нь тооллого эхлэхийн өмнө дараах бэлтгэл хангасан байх үүрэгтэй", 1.1-д "Үндсэн хөрөнгөд гарсан хөдөлгөөн, өөрчлөлтийг нягтлан бодохын дэлгэрэнгүй бүртгэлд тусгасан байх, техник, технологийн баримт бичгийг гүйцэд бүрдүүлсэн байх" заалтуудыг хэрэгжүүлээгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### **3.1.2 Эрсдэл:**

Хөрөнгө өөрийн эзэмшилд бүртгэгдээгүй, эзэмшлийн эрх үүсэхгүй байх;

##### **3.1.3 Өгсөн зөвлөмж:**

Автомашины гэрчилгээг АМГТГ-ын нэр дээр шилжүүлэх.

##### **3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Хүлээн зөвшөөрсөн хариу илүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код  | Балансын үзүүлэлт                  | Эхний үлдэгдэл           | Эцсийн үлдэгдэл          |
|-------------|------------------------------------|--------------------------|--------------------------|
| <b>1</b>    | <b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>     | <b>34,748,359,739.59</b> | <b>32,886,708,721.40</b> |
| <b>31</b>   | <b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>              | 1,641,345,296.00         | -                        |
| <b>312</b>  | <b>Банканд байгаа бэлэн мөнгө</b>  | 1,641,345,296.00         | -                        |
| <b>3121</b> | <b>Төгрөг</b>                      | 1,641,345,296.00         | -                        |
| 31211       | Төрийн сангийн харилцах            | 1,641,345,296.00         | -                        |
| <b>33</b>   | <b>АВЛАГА</b>                      | 9,084,637,972.47         | 9,084,000,275.03         |
| 33100       | Ажиллагчидтай холбогдсон авлага    | 310,691.32               | 1,099,023.99             |
| <b>335</b>  | <b>Бусад авлага</b>                | 9,084,327,281.15         | 9,082,901,251.04         |
| 3351        | Байгууллагаас авах авлага          | 9,059,425,322.62         | 9,078,015,410.80         |
| 3352        | Хувь хүмүүсээс авах авлага         | 24,901,958.53            | 4,885,840.24             |
| <b>34</b>   | <b>УРЬДЧИЛГАА</b>                  | 281,936,598.47           | 63,503,476.25            |
| 34600       | Урьдчилж гарсан зардал             | 279,917,576.25           | 61,645,076.25            |
| <b>3471</b> | <b>Урьдчилгаа тооцоо</b>           | 2,019,022.22             | 1,858,400.00             |
| 34714       | Томилолтын урьдчилгаа              | 2,019,022.22             | 1,858,400.00             |
| <b>35</b>   | <b>БАРАА МАТЕРИАЛ</b>              | 565,049,519.37           | 563,814,616.84           |
| 35300       | Бэлэн бүтээгдэхүүн                 | 4,421,290.00             | 4,579,290.00             |
| <b>354</b>  | <b>Хангамжийн материал</b>         | 560,628,229.37           | 559,235,326.84           |
| 35410       | Бичиг хэргийн материал             | 13,791,580.11            | 14,778,837.66            |
| 35420       | Аж ахуйн материал                  | 514,881,649.29           | 521,580,050.97           |
| 35430       | Сэлбэг хэрэгсэл                    | 20,040,489.91            | 20,175,049.91            |
| 35440       | Түлш, шатах тослох материал        | 11,914,510.06            | 2,701,388.30             |
| <b>36</b>   | <b>НӨӨЦИЙН БАРАА</b>               | 23,175,390,353.28        | 23,175,390,353.28        |
| 36400       | Шатахууны нөөц                     | 23,175,390,353.28        | 23,175,390,353.28        |
| <b>2</b>    | <b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b> | <b>9,684,711,913.52</b>  | <b>46,433,420,746.69</b> |
| <b>39</b>   | <b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>              | 9,684,711,913.52         | 46,433,420,746.69        |
| 391         | Газар                              | 208,169,615.00           | -                        |
| <b>392</b>  | <b>Биет хөрөнгө</b>                | 8,871,812,915.72         | 8,424,750,181.64         |
| 39201       | Барилга, байгууламж, орон сууц     | 5,363,350,894.54         | 5,363,350,894.54         |
| 39202       | Хуримтлагдсан элэгдэл              | -                        | (140,489,960.64)         |
| 39203       | Авто-тээврийн хэрэгсэл             | 2,674,534,117.94         | 2,552,310,417.94         |
| 39204       | Хуримтлагдсан элэгдэл              | (1,647,724,912.79)       | (1,880,209,999.38)       |
| 39205       | Машин тоног төхөөрөмж (компьютер)  | 7,259,284,508.42         | 7,194,270,437.24         |
| 39206       | Хуримтлагдсан элэгдэл              | (4,832,915,154.98)       | (5,468,109,035.04)       |
| 39207       | Тавилга, аж ахуйн эд хогшил        | 1,102,977,429.10         | 1,405,413,128.12         |
| 39208       | Хуримтлагдсан элэгдэл              | (845,519,418.87)         | (1,076,092,541.08)       |
| 39212       | Хуримтлагдсан элэгдэл              | (408,447,797.78)         | -                        |
| 39214       | Бусад үндсэн хөрөнгө               | 694,050,278.87           | 968,005,278.87           |
| 39215       | Хуримтлагдсан элэгдэл              | (487,777,028.73)         | (493,698,438.93)         |
| <b>393</b>  | <b>Биет бус хөрөнгө</b>            | 604,729,382.80           | 38,008,670,565.05        |
| 39301       | Программ хангамж                   | 1,669,524,379.19         | 1,697,256,021.05         |
| 39302       | Хуримтлагдсан элэгдэл              | (1,064,794,996.39)       | (1,029,443,490.73)       |
| 39303       | Бусад биет бус хөрөнгө             | -                        | 37,340,858,034.73        |
| <b>3</b>    | <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b> | <b>44,433,071,653.11</b> | <b>79,320,129,468.09</b> |
| <b>4</b>    | <b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>              | <b>2,369,498,415.75</b>  | <b>735,863,474.40</b>    |
| <b>41</b>   | <b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>   | 2,369,498,415.75         | 735,863,474.40           |
| <b>413</b>  | <b>Өглөг</b>                       | 2,369,498,415.75         | 665,183,604.40           |
| <b>4136</b> | <b>Бусад өглөг</b>                 | 2,369,498,415.75         | 665,183,604.40           |
| 41361       | Байгууллагад төлөх өглөг           | 2,369,249,401.19         | 626,145,138.00           |
| 41362       | Хувь хүмүүст төлөх өглөг           | -                        | 33,721,033.99            |
| 41363       | Татварын өглөг /ТӨҮГ/              | 249,014.56               | 5,317,432.41             |
| <b>414</b>  | <b>Урьдчилж орсон орлого</b>       | -                        | 70,679,870.00            |

|            |   |                                 |                                 |
|------------|---|---------------------------------|---------------------------------|
| 41430      | Барьцаа, дэнчингийн урьдчилж орсон орлого                             | -                               | 70,679,870.00                   |
| <b>5</b>   | <b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>                                       | <b><u>42,063,573,237.36</u></b> | <b><u>78,584,265,993.69</u></b> |
| <b>51</b>  | <b>Засгийн газрын хувь оролцоо</b>                                    | 42,063,573,237.36               | 78,584,265,993.69               |
| 511        | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 10,187,812,519.22               | 10,187,812,519.22               |
| 51106      | Эздийн өмчийн бусад хэсэг   | 10,187,812,519.22               | 10,187,812,519.22               |
| <b>512</b> | <b>Хуримтлагдсан үр дүн</b>   | 29,114,243,548.50               | 65,634,936,304.83               |
| 51210      | Өмнөх үеийн үр дүн  | 29,114,243,548.50               | 66,246,931,968.23               |
| 51220      | Тайлант үеийн үр дүн  |                                 | (611,995,663.40)                |
| 51300      | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү                                      | 2,761,517,169.64                | 2,761,517,169.64                |
| <b>6</b>   | <b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>                    | <b><u>44,433,071,653.11</u></b> | <b><u>79,320,129,468.09</u></b> |

#### 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код  | Үзүүлэлт  | Өмнөх оны гүйцэтгэл       | Тайлант оны гүйцэтгэл     |
|-------------|---|---------------------------|---------------------------|
| <b>1</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>  | <b>291,074,625,191.39</b> | <b>307,062,295,863.34</b> |
| <b>11</b>   | <b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>  | <b>42,666,881,769.12</b>  | <b>42,644,525,111.23</b>  |
| <b>118</b>  | <b>Бусад татвар, төлбөр, хураамж</b>  | 42,666,881,769.12         | 42,644,525,111.23         |
| <b>1180</b> | <b>Бусад нийтлэг төлбөр, хураамж</b>  | 42,666,881,769.12         | 42,644,525,111.23         |
| 118002      | Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр  | 39,643,480,391.50         | 37,112,360,807.79         |
| 118003      | Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр   | 3,023,401,377.62          | 5,532,164,303.44          |
| <b>12</b>   | <b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>  | <b>243,555,068,676.27</b> | <b>260,189,777,552.11</b> |
| <b>120</b>  | <b>Нийтлэг татварын бус орлого</b>  | <b>243,555,068,676.27</b> | <b>260,189,777,552.11</b> |
| 120002      | Хүүгийн орлого  | 17,830,209.72             |                           |
| 120004      | Төсөв байгууллагын өөрийн орлого  | 20,977,588,438.84         | 27,856,869,906.41         |
| 1200041     | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих   | 15,614,681,322.50         | 21,464,544,954.85         |
| 1200042     | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих   | 5,360,374,908.34          | 5,863,425,130.65          |
| 1200045     | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого   | 2,532,208.00              | 528,899,820.91            |
| 120006      | Газрын тосны орлого   | 222,546,276,147.72        | 232,267,132,458.52        |
| 120009      | Бусад орлого  | 13,373,879.99             | 65,775,187.18             |
| <b>13</b>   | <b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>  | <b>4,852,674,746.00</b>   | <b>4,227,993,200.00</b>   |
| <b>1310</b> | <b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>  | <b>4,852,674,746.00</b>   | <b>3,851,543,200.00</b>   |
| 131001      | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт   | 3,367,711,200.00          | 3,851,543,200.00          |
| 131005      | Хөрөнгийн санхүүжилт  | 1,484,963,546.00          |                           |
| <b>1311</b> | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>  | -                         | <b>376,450,000.00</b>     |
| 131102      | Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл |                           | 376,450,000.00            |
| <b>2</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>  | <b>290,782,090,311.29</b> | <b>307,674,291,526.74</b> |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>  | <b>290,782,090,311.29</b> | <b>307,674,291,526.74</b> |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>  | <b>5,566,188,003.52</b>   | <b>6,325,818,923.58</b>   |
| <b>2101</b> | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>  | <b>2,467,515,685.70</b>   | <b>2,733,888,627.82</b>   |
| 210101      | Үндсэн цалин  | 1,443,888,406.83          | 1,453,693,879.35          |
| 210102      | Нэмэгдэл  | 699,755,918.87            | 816,133,472.14            |
| 210103      | Унаа хоолны хөнгөлөлт   | 320,786,760.00            | 256,874,600.00            |
| 210105      | Гэрээт ажлын хөлс   | 3,084,600.00              | 207,186,676.33            |
| <b>2102</b> | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>   | <b>303,365,941.31</b>     | <b>344,494,731.50</b>     |
| 210201      | Тэтгэврийн даатгал  | 263,941,399.13            | 301,867,508.34            |
| 210202      | Тэтгэмжийн даатгал  | 10,224,979.64             | 11,197,587.13             |
| 210203      | ҮОМШӨ-ний даатгал   | 7,851,664.20              | 8,510,069.56              |
| 210204      | Ажилгүйдлийн даатгал  | 1,940,034.35              | 2,083,597.22              |
| 210205      | Эрүүл мэндийн даатгал   | 19,407,863.99             | 20,835,969.25             |
| <b>2103</b> | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>  | <b>152,580,258.31</b>     | <b>171,628,975.66</b>     |
| 210301      | Гэрэл, цахилгаан  | 11,282,887.80             | 23,026,234.92             |
| 210302      | Түлш, халаалт   | 110,707,368.88            | 79,977,776.67             |
| 210303      | Цэвэр, бохир ус   | 11,190,944.63             | 9,600,464.07              |
| 210304      | Байрны түрээс   | 19,399,057.00             | 59,024,500.00             |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>   | <b>261,329,485.47</b>     | <b>209,765,245.84</b>     |
| 210401      | Бичиг хэрэг   | 53,714,925.74             | 45,051,086.73             |
| 210402      | Тээвэр, шатахуун  | 81,732,068.99             | 63,373,645.63             |
| 210403      | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр  | 36,885,208.49             | 37,114,715.16             |
| 210405      | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал   | 845,000.00                | 380,000.00                |
| 210406      | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс   | 74,655,292.85             | 63,845,798.32             |
| 210408      | Бараа материал акталсны зардал  | 13,496,989.40             |                           |
| <b>2105</b> | <b>Норматив зардал</b>  | <b>1,000,000.00</b>       | <b>725,120.00</b>         |

|             |   |                           |                         |
|-------------|---|---------------------------|-------------------------|
| 210503      | Нормын хувцас, зөөлөн эдлэл   | 1,000,000.00              | 725,120.00              |
| <b>2106</b> | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                                    | 96,136,234.58             | 132,312,064.13          |
| 210601      | Багаж, техник, хэрэгсэл   | 186,640.00                | 320,000.00              |
| 210604      | Урсгал засвар   | 95,949,594.58             | 131,992,064.13          |
| <b>2107</b> | <b>Томилолт, зочны зардал</b>   | 321,054,105.73            | 320,455,143.11          |
| 210701      | Гадаад албан томилолт   | 141,993,502.35            | 195,626,911.00          |
| 210702      | Дотоод албан томилолт   | 177,007,466.80            | 122,978,232.11          |
| 210703      | Зочин төлөөлөгч хүлээн авах   | 2,053,136.58              | 1,850,000.00            |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>             | 659,597,372.48            | 651,456,799.23          |
| 210801      | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж        | 585,269,073.24            | 573,263,748.03          |
| 210802      | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох                                    | 2,670,000.00              | 800,000.00              |
| 210803      | Даатгалын үйлчилгээ   | 30,298,326.00             | 32,545,732.00           |
| 210804      | Тээврийн хэрэгслийн татвар  | 5,832,905.00              | 5,713,401.00            |
| 210805      | Тээврийн хэрэгслийн оношилгоо   | 491,500.00                | 1,040,200.00            |
| 210806      | Мэдээлэл, технологийн үйлчилгээ   | 28,436,794.24             | 30,436,710.20           |
| 210807      | Газрын төлбөр   | 4,114,844.00              | 2,829,512.00            |
| 210809      | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх                                      | 2,483,930.00              | 4,827,496.00            |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                                      | 1,303,608,919.94          | 1,761,092,216.29        |
| 210901      | Бараа үйлчилгээний бусад зардал   |                           | 188,053,539.73          |
| 210903      | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол  | 1,303,608,919.94          | 1,573,038,676.56        |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>   | 285,215,902,307.77        | 301,348,472,603.16      |
| <b>2131</b> | <b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>                                      | 4,600,000,000.00          | -                       |
| 213101      | Засгийн газрын дотоод шилжүүлэг   | 4,600,000,000.00          |                         |
| <b>2132</b> | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>   | 1,970,324,037.47          | 2,623,334,122.76        |
| 213204      | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал                              | 90,637,185.16             |                         |
| 213205      | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал                                    | 1,845,742,452.31          | 2,329,424,937.18        |
| 213207      | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж                         | 33,944,400.00             | 171,732,218.69          |
| 213209      | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                                     | -                         | 122,176,966.89          |
